

А. Камюгийн абсурдист философи

Р.Дарьхүү - МУИС.НШУС.Философийн тэнхмийн эрхлэгч, профессор
Я.Мөнхчимэг – Улаанбаатар хотын “Хобби” сургуулийн багш

Түлхүүр үгс: утга учиргүйдэл, тэрсэлдээн, эрх чөлөө, сонголт, үхэл, амиа хорлолт, ганцаардал, айдас

Хүн гэж хэн бэ?, хүний амьдралын утга учир гэж юу вэ? гэсэн амаргүй асуултанд эрдэмтэн мэргэд эртнээс эдүгээ хүртэл янз бүрийн хариулт өгч ирсэн билээ. Хүний амьдралын утга учир, хүний мөн чанарын асуудалд иррационал философи, тэр дундаа экзистенциалистуудын өгсөн хариулт өвөрмөц бөгөөд сонирхолтой байдаг юм.

Хүний оршихуйн нууцыг нээх, ойлгох асуудлаар францын экзистенциалист философич А.Камю өвөрмөц үзэл санааг дэвшүүлсэн байна. Хүний оршихуй нь мөн чанараараа субъектив зүйл болохыг, хүний амьдралын утга учир нь оюун санаалаг мөн чанараар нөхцөлддөг болохыг тэрээр авч үзжээ. Хүний амьдрал, түүний утга учир нь хүний дотор, хүнээс өөрөөс нь шалтгаалж байдаг болохыг тэрээр абсурд буюу утга учиргүйдэл, тэрсэлдээн гэсэн ойлголтуудаар тайлбарлажээ.

Хувь хүний ганцаардмал шинж хийгээд хүний оршихуйн төгсгөлөг шинжтэй холбоотойгоор А.Камюгийн философид яригддаг үндсэн ойлголт нь “утга учиргүйдэл” юм. А.Камю “Сизифийн тухай домог” зохиолдоо энэхүү утга учиргүйдлийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Энэ бүтээлд “хүн эцэстээ үхэх юм бол амьдрах хэрэг юу байна вэ?” гэдэг асуудлын талаар тайлбарласан буй.

Тэрээр “амьдралыг үргэлжлүүлэхийн тулд амьдрах уу? Эсвэл амьдрахгүй юу гэдгийг шийдэх нь философийн суурь асуудал” хэмээн үзсэн буй. Утга учиргүйдлийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Бидэнд аажим аажмаар юм бүхнээс зайлсхийх мэдрэмж төрдөг. Эргэн тойрны хорвоо ертөнцийг бид хэзээд хатуу ширүүн гэж ойлгож ирсэн. Хүн бүр энэ ертөнцөд өөрсдийн хүсэл зориг, төрх байдлаа үгүйсгэхийн зэрэгцээ сэтгэл нь чулуу мэт болж, улам бүр энэ ертөнцөд өөрийгөө харийн гадны болохоос мэдэрдэг байна. Энэ нь үнэндээ өөрийгөө үгүйсгэж байгаа хэрэг юм.

Хүний амьдралд мөнхийн байдаг зүйл нь айдас, түүний онцлог нь өөрийгөө итгүүлэх, тайвшруулах боломж олгодоггүй. Айдас нэгэнт сэтгэлд төрсөн бол хүнийг бүхэлд нь эзэмддэг. Энэ нь хүнийг аймшигтай ганцаардлын байдалд оруулдаг бөгөөд энэ бүхнээс болж хүн амьдралд итгэх итгэлээ алддаг. Амьдралаа өөдрөгөөр харах хандлага, бүтээлч байдлыг алдагдуулдаг. Тиймээс айдас нь хүн, хүний оршихуйд шууд чөлөөлдөг үзэгдэл ажээ. Айдас хийгээд өөрийгөө үгүйсгэх мэдрэмж нь хүнийг утга учиргүйдлын байдалд оруулдаг.

Нөгөө талаар үүнд хүний мэдлэг нөлөөлдөг. А.Камю хүн хэзээ ч үнэнийг танин мэдэж чадахгүй гэж үзсэн ба тэрээр “Би юу мэдэх вэ?” гэж асуусан. Энэ асуултандаа хариулахдаа: “Би өөрийн мөн чанараараа зүрхний цохилтоо мэдэрч байна. Би өөрийн орчин тойрны ертөнцийг ухамсарлаж байна, түүний мөн чанарыг нь мэдэж байна гэж бодож байна. Үүгээр миний мэдлэг дуусч байгаа ба цаана нь асар их зүйл үлдчихсэн юм шиг санагдана. Түүнийг танин мэдэх, эмхлэх хэрэгтэй. Миний дотоод мөн чанар үнэн хоёр хоорондоо ялгаатай ба би энэ мэдрэмжээс зайлж чадахгүй. Би үргэлж өөрийгөө харийн хүн мэт үздэг. Хүн өөрийн амьдралын утга учрыг тайлбарлах, амьдралаа хялбар болгохын тулд шинжлэх ухааныг бий болгосон. Гэхдээ шинжлэх ухаан

тийм ч төгс биш. Шинжлэх ухаан ертөнцийг хүнд ойлгуулах ёстой боловч чаддаггүй, чадах ч үгүй. Миний хүссэн тэр зүйлийг шинжлэх ухаан өгдөггүй. Энэ нь зүрх сэтгэлийн өмнө оюун ухаан хүч мөхөсдөж байдаг. Шинжлэх ухааны танин мэдэхүй нь хүүхдийн асуултанд л хариулт өгдөг. Хүн төрөлхтөний танин мэдэхүй нэг талаас, бүхнийг танин мэдэх гэсэн хүний оюун ухааны тэмүүлэл, нөгөө талаас энэ нь боломжгүй гэдгийг ухаарсан ухаарлын хооронд хөлбөрч байдаг”¹¹ гэжээ.

“Шинжлэх ухаан үзэгдлийг танин мэддэг ч тэр хэзээ ч миний дотоод ертөнцийг таньж чадахгүй. Учир нь энэ ертөнц, надаас бусад бүх зүйлс харийн болоод л тэр” гэж тэрээр хариулжээ. Үнэндээ хүний оюун ухаанаас гадна орших утга учиргүйдлын асуудал байхгүй. Хүн өөрөө утга учиргүйдлын баталгаа юм. Эндээс А.Камюгийн хүний тухай үзэл тодорч ирдэг.

А.Камюгийн философид хувь хүнийг дээдлэх үзэл, хүний оршихуйн утга учиргүй байдлын шалтгааныг тал бүрээс нь авч үзсэн. Түүний үзлээр, хувь хүн бүрийг тойрсон өөр өөрийн гэсэн нийгмийн болон байгалийн орчин байдаг ба бурханд итгэхээ больж, хувийн амьдрал нь мөхлийн ирмэгт тулахад хүнд ямар байхыг дүрсэлжээ. Энэ үед амьдрал ямарч утгагүй мэт санагдана. Бурханд итгэх итгэл нь хүний субъектив шинж чанарыг нь үгүйсгэдэг. Бурханд шүтсэнээр хүн өөрийгөө трансцендентэд аваачиж өөрөөсөө холддог. Тиймээс бурхан бол хүнийг мөн чанараас нь холдуулагч, утга учиргүйдлын нэг түлхэлт буюу шалтгаан болдог зүйл юм.

Хамт олны дунд байгаа хүн бол хүнтэй байгаа хүн биш ба амьдралын хамтран зүтгэгчидтэй холбоо байгуулснаараа бие хүн ганцаардлаасаа ангижирдаггүй, ганцаардал нь бие хүний дотоодод үлддэг. А.Камюгийн үзлээр, хувь хүн хамт олонтой байх нь түүний тусгаарлагдмал байдлыг арилгадаггүй, харин өнгөлөн далдалж байдаг боловч уг бодит төлөв байдал мөн учраас гүндээ арилалгүй үлддэг бөгөөд аажмаар өссөөр байгаад хамтач үзлийн хана нь нурж унахаар хүчтэйгээр сэдрэн гарч ирдэг гэжээ. Тэрээр орчин үеийн хамтач үзэл бол хүнийг өөрөө өөртэйгээ хийх уулзалтаас халхлан хөндийрүүлж байгаа хөшиг гээд, бусадтай байхдаа хүн өөрөө өөрийгөө алддаг ба тэнд хүн хамт олны нэг хэсэг төдий амьгүй зүйл болж хувирдаг. Тиймээс түүний амьдрал нэг талаас утга учиргүй болдог гэжээ. Ийнхүү хүний амьдрал дах айдас, хүнийссэн байдал, ганцаардал, альтруист шинж, мэдлэг зэрэг нь хүнийг утга учиргүйдлийн байдалд хүргэдэг хүчин зүйлүүд юм. Ерөөсөө утга учиргүйдэл нь хүний дотоод сэтгэлийн ертөнц дэх зөрчлийн үр дүнд үүсдэг. Энэ зөрчил нь иррационал зүйл болон тодорхой дур зорго хоёрын хооронд хүний сэтгэлийн гүнд болдог. Өөрөөр хэлбэл, утга учиргүйдэл нь оюун ухааны бус чимээгүй ертөнц ба хүний хувь тавилан хоёрын зөрчлийн үр дүнд үүсдэг.

А.Камю абсурдист үзэлдээ утга учиргүйдэл үүсэх нөхцөлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд, утга учиргүйдлийг хүн ухамсаргүйгээр ухамсарлан ойлгодог ба гэнэт өөрөөсөө энэ бүхний утга учрыг хайж, өөрөө өөртөө асуулт тавьж эхэлдэг. Би хэн бэ?, миний амьдрал юу болоод байна аа?, үүнд утга учир байна уу, үгүй юу? Би бусдаас заавал хараат байх ёстой гэж үү? гэх мэтийн асуултууд ар араасаа урган гардаг. Эдгээр асуултанд хариулт олох үедээ тэрээр ганцаардмал байдлыг мэдэрч эхэлнэ. “Ганцаардал бол хүнд оюун санааны дээд зэргийн таашаал өгдөг, оюун санааны эрхэм таатай байдал”¹² хэмээн А. Камю үзсэн ба утга учиргүйдлээр нөхцөлдсөн ганцаардлыг ганцхан үхэл л нөхөж чадна хэмээжээ.

¹¹ www.best.ru from Альберт Камю

¹² А.Камю “Миф о сизифе”, “Бунтующий человек”. Минск., 1998.с.217

Утга учиргүйдлийн мэдрэмж зөвхөн хүний ертөнцөд байдаг. Энэ хорвоо бол бүх юм өгөгдсөн атлаа боломжтой зүйл юу ч үгүй хорвоо. Иймээс хүн өөрийгөө олж, утга учиртай амьдрах хэрэгтэй. Утга учиргүйдэл бол хүний үйл ажиллагааны чөлөөт байдлыг алдагдуулж, хүнийг эзэн биегүй болгодог ба хүн ертөнцтэй харилцах харилцаа нь болж өгдөг тэр зүйл юм.

Абсурд хүнд буюу утга учиргүйдлийг мэдэрсэн хүнд зөв сэтгэх, бусдыг зөвтгөх шалтгаан байхгүй, “бүх зүйл зөвшөөрөгдсөн”, тэр өөрийн зарчмаар явна. “Бурхан амьдралд сайн сайхан, утга учрыг өгсөн” бүх зүйл зөвшөөрөгдсөн гэхдээ энэ нь эрх чөлөөтэй гэсэн үг бас биш. Тиймээс энэ дэлхий утга учиргүйдлээр дүүрэн юм. Мэдээж энэ дэлхий дээрх ихэнх зүйл хүний гараар бүтээгдсэн. Хүн өөрөө утга учиргүйдлыг бий болгодог. Энэхүү утга учиргүйдэл нь үнэ цэнэтэй амьдрал болж хэмжигддэг. Сизифийн тэмцэл нь хүний зүрх сэтгэлийг илрүүлэхэд хангалттай. Хүмүүсийн ихэнх нь өөрсдийн амьдралыг маргааш гэсэн хүсэл дээр бий болгодог. Гэтэл бидний хүсч байсан маргааш, өдөр өдрөөр үхлийг бидэнд ойртуулдаг. Үхэл бол бидний туйлын дайсан”¹³ хэмээн А.Камю үзсэн буй.

Түүний үзлээр, “Нэгэнт хүний амьдрал богинохон учраас хайр байх боломжгүй. Энэ бол утга учиргүй зүйл. Хэрэв ертөнцийн бүх юм ойлгомжтой байсан бол урлаг байхгүй байсан. Бид итгэл үнэмшил хүсэл зэрэг олон зүйлийг өөртөө агуулж байдаг. Тийм ч учраас хүн төрөлхтөн урлагийг бүтээдэг. Бидний оюун ухаанаас гарч байгаа бүтээл нь абсурд бүтээл юм. Амьдралынхаа өдөр болгон нэг л зорилготойгоор өдөржин ажиллана гэдэг бол утга учиргүй. Гэхдээ ингэж байна гэдгээ хааяа ойлгох нь эмгэнэлтэй хэрэг. Хувь тавилан бол бидэнд оноосон ял шийтгэл биш. Гагцхүү хүн өөрөө л түүнийг ял шийтгэл болгон хувиргадаг”¹⁴.

Түүнчлэн, “Ертөнц бол харийн зүйл. Үнэн бол танин мэдэх боломжгүй зүйл. Ер нь бол рационал ухаан, шинжлэх ухаан ертөнцийг хангалттай тайлбарлаж чадахгүй. Тэдгээр тайлбар нь ихэвчлэн хийсвэрлэл, утга учиргүйдэлд аваачдаг”¹⁵. Энэ нь ертөнц утга учиргүй, хүний бодол утга учиргүй гэсэн үг биш. Утга учиргүйдэл хэзээ үүсдэг вэ гэхээр энэ ойлгомжгүй байдлыг ойлгое гэсэн хүний хүсэл нурах үед утга учиргүйдэл үүсдэг. Хүн байхгүйгээр утга учиргүйдэл хэзээ ч үүсэхгүй. Эцэст нь түүнд бууж өгөхөөс өөр арга үлдсэнгүй. Гэхдээ тэр эрх чөлөө, хязгааргүй тайван байдлыг мэдэрч байна. Амьдрал дээр хүн “Хачин хүн” зохиолын Мерсолт шиг бууж өгөх биш, харин энэ амьдралын төлөө тэмцэж, утга учиргүйг тэрсэлж амьдрах ёстой гэж А.Камю үзсэн билээ.

А.Камю хүний амьдралыг, амьдрал бол эмх замбараагүй бөгөөд бузар муухай бие болоод сэтгэлийн гэмт үйлдлээр дүүрэн байдаг гэжээ. Ер нь хүний амьдрал бол унаж босохын ирмэг дээр байнгын хэлбэлзэж байдаг ба унах уу?, сэхэх үү? гэдэг сонголтыг ямагт хүн өөрөө л хийж байдаг. Иймд утга учиргүйдлээр дүүрэн энэ амьдралыг дагаж биш, сөрж амьдрах хэрэгтэй ба ингэж чадвал хүний амьдрал утга учиртай, үнэ цэнэтэй болох болно.

Өмнө өгүүлснээс дүгнэн хэлбэл, утга учиргүйдэл бол бүрэн танин мэдэж, ойлгож чадахгүй байгаа ертөнц, түүнийг туйлын байдлаар ойлгох гэсэн хүн хоёрын зөрчлийг илэрхийлсэн ойлголт юм. Амьдралын утга учрыг эрж хайсан хүн л утга учиргүйдэл, түүний мөн чанарыг илүү танин мэднэ. Гэвч хүний орших цорын ганц найдвар нь өөртөө итгэх итгэл юм. Хүн нийгмээс, амьдралаас хүссэнээ олж авах боломжгүй байлаа ч гэсэн өөрийнхөө хувьд амьдралын утга учрыг тодорхойлох боломжтой ажээ. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын утга учир,

¹³ “Absurd man” from – www.google.com

¹⁴ А.Камю. “Миф о Сизифе”, “Бунтующий человек”. Минск., 1998. с.85

¹⁵ Альберт Камю from www.best.ru

үнэ цэнэ гол нь хүнээс өөрөөс нь шалтгаална гэсэн чухал үзэл санааг тэрээр дэвшүүлсэн буй.

А.Камюгийн философийн үндсэн сэдэв нь хувь хүний амьдрал, түүний оршихуйн утга учрын асуудал юм. Түүний үзлээр, хүний оршихуй нь үхлээр хязгаарлагддаг ба энэ асуудал нь цаг хугацааны асуудалтай холбогддог. Утга учиргүйдлийн нэг баталгаа нь амьдралын эсрэг ойлголт болох үхлийг сайн дураараа сонгож буй амиа хорлох үзэгдэл юм. Энэ нь утга учиргүйдлээс зугтах нэг арга юм. Үүний цаана, хүн өөрт нь амьдралд бүрэн дүүрэн итгэх итгэл найдвар байхгүй ч гэсэн эрх чөлөө байгаа юм гэдгийг харуулж байна. Тэрээр “амиа хорлоно гэдэг нь хоосон зорилгынхоо төлөө хоосон амьдралыг туулах гэсэн сонголтын нэг хэлбэр. Амьдрал бол утга учиргүйдлээр дүүрэн. Тиймээс үүнээс зугтах гэсэн нэг оролдлого нь амиа хорлолт”¹⁶ гэж үзсэн.

Энэ талаар А.Камю хэлэхдээ: “Хүн өвдөх тусмаа цаг үргэлж, минут тутамд амьдралыг мэдэрдэг, амьдарч байгаагаа ухаардаг”, “Би амьдралд дуртай, амьдрах хүслийн тухай эргэцүүлэн бодоод бүх нөхцөл байдлаас чөлөөлөгдөхийг хүсэхгүй байна.”, “Би үхлээс айдаг, тэр намайг гайхшруулдаг. Гуниг алга болоход үхэл тулж ирэн амьдрал төгсдөг. Тиймээс нөгөө талаасаа би амьдрахыг хүсэхгүй байна. Учир нь энэ бол хэтэрхий ойрын болоод мэдрэгдэхүйц зүйл юм”¹⁷ гэжээ. Амиа хорлолт, аллага хоёр бол нэг зоосны хоёр тал гэж А.Камю нэгэнтээ хэлсэн байдаг.

А.Камю хүний амьдрал ямагт утга учиргүй байдаг гээд, дараах асуултыг тавьсан. Үүнд:

-Утга учиргүйдлийг танин мэдэх явдал нь амиа хорлохыг шаарддаг уу? гээд,

-Үгүй. Утга учиргүйдлийг танин мэдэх нь тэмцлийг шаарддаг.

Үхэл нь мөнхийн гэсэн ойлголтыг үгүйсгэдэг ба энэ нь онтологийн утгаараа үхэл, түүний ахуй руу дайсагнах, ахуй бус руу дайрах оролдлого юм. Үхэл нь бурхны бүтээл болсон ертөнц болоод ахуй бусыг сэргээх гэсэн оролдлогыг эсэргүүцэж байгаа эсэргүүцэл юм. Үхэл нь бурхны утга учир, ертөнц бол бурхны хүсэл зориг гэсэн нотолгоог үгүйсгэж утга учиргүйн баталгаа нь болдог. Буянт сайн үйл нь амьдралд л байдаг ба зориг болон төгс төгөлдөр амьдрал зэрэг нь мөнхийн амьдралын ойлголт юм. Мөнхийн амьдрал гэж байхгүй учраас энэ нь шашны утгатай ойлголтууд гээд, үхэл нь бидний өдөр тутмын амьдралд оногдуулсан ухаангүй зүйл хэмээн А.Камю үзжээ. Амьдрах, энэ нь туйлын байгаллаг үзэгдэл, тэр биологийн хувьсалд ашигтай, чухал хэрэгтэй үүрэг гүйцэтгэдэг.

Үхэл нь газар сайгүй байгаа бүх хүмүүсийн нийтлэг хувь тавилан, нийтлэг гуниг гутралыг илтгэдэг. Тэр гүнзгий сэтгэл хөдлөл, шаргуу байдлыг онцлон тэмдэглэдэг хувь заяаны төгсгөлтэй нэгдэхийг оролддог. Үхэл нь бүхэлдээ хүмүүсийн нөхөрлөлийн тухай, харилцаа холбоо, орчин үеийн түүх зэргийн талаарх бүх асуудлыг багтаадаг.

Ийнхүү амьдралд заналхийлж байгаа тэр зүйлийг хүний амьдрал дах утга учиргүйдэл гэж үзэж байна. Учир нь утга учиргүйдлийн мэдрэмж бол хүнийг цөхрөл гутралд хүргэдэг. Утга учиргүйдэл хүнийг нийгмээс тусгаарлаж, өөрөөс нь холдуулдаг ба амьдралын үнэ цэнийг алдагдуулж, эцэст нь үхэлд хүргэдэг. Харин амьдрах хүсэл тэмүүллийг арав дахин нэмэгдүүлж буй тэр зүйл нь амьдрал дах утга учиргүйдлийг ойлгосны үндсэн дээр түүнтэй тэмцэж, тэрсэлж байгаа тэр хүний мөн чанар нь юм. Тиймээс тэрсэлдээн болон утга учиргүйдэл нь хүний орших уу, эс орших уу гэдгийг тодорхойлогч хоёр туйл мөн.

¹⁶ Альберт Камю from www.best.ru

¹⁷ Е.П.Кушкин. Альбер Камю (ранние годы) Ленинград.1982 стр-20

Тэрээр "Сизифийн тухай домог"-т утга учиргүйдлийг Сизифийн нөхцөлтэй харьцуулсан байдаг. Мөн хүний амьдралын утга учрыг А.Камю тодорхойлохдоо: "Хүн оюун ухаанаараа хувь заяагаа ухаарч, амьдралын дарамтыг үүрч, түүнтэй эвлэрэхгүйгээр үр өгөөжтэй, бүрэн дүүрэн тэмцэж амьдрах болсноор түүний амьдрал утга төгөлдөр болно" гэжээ. Түүнчлэн А.Камю утга учиргүйдлийн амьдралыг даван туулахын тулд хүн тэрсэлдэх ёстой хэмээн үзсэн.

Тэрсэлдээн бол А.Камюгийн абсурдист философийн нэг үндсэн ойлголт юм. Түүний үзлээр, тэрсэлдээн нь утга учиргүйдлийг даван туулах нэг үндсэн арга зам мөн. "Тэрсэлдээн бол эрхээ бат ухамсарласан хүний үйлдэл" юм. Хүн төрөлхтөний түүхэнд, хүнд өөрийнх нь хувь тавилан ойлгомжгүй, шударга бус ба хүний ахуй нь утга учиргүйдлээр дүүрэн мэт ухамсарлагддаг. Тэрсэлдээний үндсэн шалтгааныг А.Камю "Хүн ганцаардмал мөн чанартай, тэр өөрийн ахуйгаа ямагт үл зөвшөөрдөг" гэж хэлсэн бөгөөд энэ нь хүний мөнхийн тэрслэгч шинжийг илтгэж байдаг ба "Дэлхий, тэнгэр, бурхан, мөрөөдөл гээд энэ бүгд хайрын зүйлс, харин амьдрах худал хуурмаг ба энд тэрсэлдээн л хангалттай"¹⁸ гэж тэрээр үзсэн байдаг.

А.Камюгийн үзлээр, "Тэрсэлдээн бол хүний уг чанарт байдаг нууцлагдмал боолын шинжийг эсэргүүцэн байгаа эсэргүүцэл, бослого юм. Тэрсэлдээн нь хувь хүн болж төлөвших, хувийн эрхэм чанараа мэдрэх явдал юм. Мөн тэрсэлдээн нь хүн төрөлхтөний эрх чөлөөний үнэт зүйл төдийгүй, хүнийсэх байдлыг даван туулах үйл явдал юм"¹⁹ гэж үзсэн байдаг. Учир нь тэрслэгч хүн бол өөрийн эрх чөлөө болон үүрэг хариуцлагаа хамгийн сайн мэдсэн, ойлгож ухаарсан хүн юм. Амьдралын утга учрыг алдагдуулж байгаа утга учиргүйдлийн асуудал нь аажмаар хүнийслийг бий болгодог.

Тэрсэлдээн гэсэн ойлголтыг тодорхой болгохын тулд юуны өмнө тэрслэгч хүний асуудлыг авч үзэх хэрэгтэй. А.Камюгийн философи дах тэрслэгч хүн бүгдийн өмнөөс зоригтойгоор "үгүй" гэж хэлж чаддаг төдийгүй, хүний амьдралынх нь хэмжээ, хязгаар болж байгаа цаг хугацааг хүлээн зөвшөөрч байгааг эсэргүүцэн, амьдрал нь эмх цэгцтэй байгаагийн эсрэг нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрдөг. Тэрсэлдээн өөрийн гэсэн тодорхой үнэлэмжийг (үнэ цэнийг) агуулдаг. Энэ нь нэгдүгээрт; тэрслэгч хүн бүгдтэй, бүгдийн үнэлэмжтэй нь харшилдаг, түүнд энэ бүхэн огт хамаагүй. Хоёрдугаарт; тэрсэлдээн зөвхөн хэн нэгний тодорхой нөхцөл байдал биш, хувь хүний өөрийнх нь хувь заяа болдог ач холбогдолтой.

Тэрсэлдээн нь боол өөрийгөө зочин мэт, гадны сэтгэгдлээр үзэхээс эхэлдэг. Үүнийг А.Камю тодруулахдаа: "Боол урьдын эмх цэгцтэй байдлыг үгүйсгэн, дарлагдсан бүх хүмүүсийн төлөөлөл болж эсэргүүцэн босдог. Хувь хүний үнэлэмжинд нөлөөлөхгүйгээр хамгаалах зорилготой ба бүх хүмүүсийг эмх цэгцэнд оруулах зорилготой юм."²⁰ гэжээ. Энэ үйл явцыг илэрхийлсэн Камюгийн боловсруулсан ойлголт нь тэрсэлдээн болон уурсал, хилэгнэл юм. Хилэгнэл нь атаархал жөтөөрхөлд уриалдаг. Тэрсэлдээн нь бие хүнийг хамгаалах зорилго тэмүүлэлтэй байдаг. Тэрсэлдээн нь бас өөрийгөө хамгаалдаг ба түүний зорилго нь өөрийгөө бие хүн гэдгийг мэдэж, гадны нөлөөнөөс өөрийгөө хамгаалах хүсэлтэй болгодог хүчин зүйл юм.

А.Камюгийн үзлээр, хүн ертөнцөд зөвхөн инстинктээрээ оршин байдаг. Хэрвээ хүн өөрийн дураар амьдралаа орхиж явсан бол магадгүй ертөнц хүнд харь, ондоо байж, улмаар түүнд дайсангаж байхад амьдралыг үргэлжлүүлэх хэрэг байхгүй гэдгийг ухааран ойлгосноос байж болох юм. Ямар нэгэн байдлаар

¹⁸ Е.П.Кушкин. "Альбер Камю" Ленинград., 1982. с.20

¹⁹ В.Г.Горбачев. "История философии". Брянск., 2000. с.254

²⁰ Альберт Камю from- www.best.ru

тайлбарлагдаж байгаа ертөнц бол бидний танил, дассан ертөнц юм. Гэвч орчлон ертөнц гэв гэнэт хуурмаг үзэгдэл болж, учир нь ойлгогдохоо боливол хүн шууд л өөрийгөө гадны, хөндлөнгийн юм шиг ойлгодог. Энэ байдал хүнд цөллөг мэт санагдаж, өөрийн итгэл найдвар, эх орноо алдсан мэт мэдрэмж төрж, амьдрах хүсэл төрөхөө болино. Яг л "Хачин хүн"-ий Мерсолтын амьдралын төгсгөлтэй адил мэдрэмж тэрслэгч хүнд мэдрэгдэнэ.

Амьдралын механик төлөв байдлын хэд хэдэн дайралтын эцэст уйтгарлал, бүх юм ядаргаатсан гэдэг мэдрэмж төрдөг, мөн тэр ухамсрыг сэргээдэг. Энэ дайралт нь хүний амьдралын зовлон, шаналал, ганцаардал юм. Энэхүү сэргэлтийн эцэст амиа хорлолт эсвэл эдгэрэлт л үлддэг. Ер нь бид амьдарч байхдаа ирээдүй рүүгээ явж байдаг ба мөн цаг хугацаа биднийг авч явахыг тайван хүлээн өдөр сарыг өнгөрүүлж байдаг. "Маргааш", "дараа нь" чи үүнийг том болохоороо ойлгоно, ийм үгнүүдийг өдөр болгон л сонсож болно.

Гэвч хүн өөрийгөө муруй замаар явж байгаагаа, тэр нь одоо тодорхой хэмжээний зам үлдсэн ба тэгээд өөрийнхөө төгсгөл рүү ойртож байгаа гэдгийг ухамсарлах өдөр ирдэг. Хүн цаг хугацааны мэдэлд байдаг ба түүнд автсан айдсаараа хүн өөрийнхөө хамгийн муу дайснаа мэддэг. Тэр бол үхэл юм. Маргааш, чи дандаа л маргааш руу тэмүүлж байдаг. Харин бүх л юм маргаашийг эсэргүүцэх ёстой байдаг. Чи үхлийг эсэргүүцэх ёстой. Энэхүү биеийн тэрсэлдээн нь утга учиргүйдэл юм.

Хувь тавилангаа мэдэрнэ гэдэг бол амьдралыг бүрэн бүтэн хүлээж авна гэсэн үг юм. Утга учиргүйдэл нь бидэнд тодорхой бөгөөд хүний ухамсарт илэрхий байгаа тэр тохиолдолд утга учиргүйгээр амьдарч болно. Утга учиргүйдлийг устгана гэдэг бол утга учиргүй зүйлээс зугатааж байгаа хэрэг юм. Ухамсарт тэрсэлдээнийг үгүй хийнэ гэдэг бол утга учиргүйдлыг эргээд сэргээнэ гэсэн үг. Утга учиргүйдлын оршин байх нөхцөл нь түүний үл шийдэгдэх чанар юм. Утга учиргүйдлыг хүлээн зөвшөөрсөн хүн бүхнийг үгүйсгэж эцэст ялагдаж, сул дорой байдлаар үхдэг. Амьдралын утга учрыг олж чадахгүй хэмээн боддог хүмүүс эцэстээ амиа хорлодог. Тэд утга учиргүйдэлд бууж өгдөг. Энэ бол ямар ч эсэргүүцэл, тэмцэлгүй, сул дорой байдлаар ялагдаж байгаа хэрэг юм.

Амьдралын тухай эргэцүүлэн бодоход амьдрал нь хөндий хоосон, ганцаардмал, өөрийн амьдралаас хэзээ ч амар амгалан, энх тайван байдлыг мэдэрч байгаагүйгээ ухаарахын хирээр ганцаараа байх нь түүнд таалагдаж эхэлнэ. Ганцаараа байх нь эрх чөлөөг мэдрүүлнэ. Чухам ганцаараа байснаараа жинхэнэ өөрийн амар тайван байдал гэгчийг мэдэрч чадаж байсан бөгөөд тиймдээ ч тэрээр аз жаргалтай, баяр баясгалантайгаар хорвоог орхидог.

А.Камю ганцаардал хэмээх үзэгдлийг хүний оршихуйн утга учиргүй байдал, амиа хорлох шалтгаан зэрэгтэй холбож өгсөн юм. Ганцаардал бол нэг талаасаа нийгмээс тусгаарлагдсан, гадуурхагдсан байдал, харин нөгөө талаасаа энэ нь хүний өөрөө өөрийгөө танин мэдэх, өөрийнхөө мөн чанар, оршихуйгаа эрж хайх эрэл юм. Хүн ганцаардсан үедээ л өөрийнхөө тухай бодож эхэлдэг. Тиймээс ганцаардал нь нэг талаасаа нийгмээс түр ч атугай ангижирч байгаа тэрсэлдээний нэг хэлбэр гэж үзэж болох юм.

Иррационалист философичид хувь хүний эрх чөлөөний асуудлыг сонголттой холбон тайлбарлаж ирсэн байдаг. Хүний амьдралыг авч үзэхдээ, "амьдрах уу, эс амьдрах уу" гэсэн сонголтын ирмэгт тулж очсон хүний сэтгэл зүй, болоод ахуйн мөн чанараар нь голлон тайлбарладаг. Эрх чөлөөний гадаад хүчин зүйлс гэдэгт оршин буй нийгмийн хөгжил, хүмүүсийн хоорондын харилцаа зэрэг ордог бол эрх чөлөөний дотоод хүчин зүйлд хувь хүний сэтгэл зүй, оршихуйн утга учир зэргийг багтаан авч үзэж болох юм. Эрх чөлөө нь угаас хязгаартайн дээр хязгааргүй эрх чөлөө нийгэмд эмх замбараагүй байдлыг үүсгэдэг билээ.

Сизифийг гаднаас нь харахад бурхны, өөрөөр хэлбэл, амьдралын тоглоом юм шиг хэрнээ энэ нь асар их тайтгарал, аз жаргал олж авахад нь тус болж байгаа хэрэг. Хүнд буй эрх чөлөөний тухай үзэл санаа нь түүний мөн чанартай холбоотой бөгөөд хүн бол байгаагаараа байхыг үл хүсэгч цорын ганц бодгаль юм. Энэ бол эрх чөлөөний дотосд сэдэл. Үүнээс гадна гадаад хүчин зүйл байх бөгөөд энэ нь тухайн хүн (боол ч бай, эзэн ч бай) “энэ ч арай хэтэрч байна” гэж үзэх явдал байдаг.

Тэрээр “Бүрэн танин мэдээгүй байгаа, ойлгогдохгүй байгаа, цаашилбал юу болох нь тодорхойгүй байгаа ертөнц, түүнийг туйлын байдлаар ойлгох гэсэн хүн хоёрын зөрчил бол утга учиргүйдэл юм. Амьдралын утга учрыг эрж хайсан хүн л утга учиргүйдлыг мэдэрнэ. Амьдралын эсрэг ойлголт болох үхлийг сайн дураараа сонгож байгаа нь утга учиргүйдлээс зугтах нэг арга ба утга учиргүй ертөнцийн баталгаа нь болдог. Үүний цаана хүнд бүрэн дүүрэн итгэл найдвар байхгүй ч гэсэн эрх чөлөө байгаа гэдгийг хэлж байгаа юм. Гэвч хүн орших цорын ганц найдвар нь хүн өөртөө итгэх итгэл юм. Хүн нийгмээс, түүхээс, амьдралаас хүссэнээ авах боломжгүй байлаа ч гэсэн өөрийнхөө хувьд амьдралын утга учрыг тодорхойлж болно”²¹ гэж үзжээ.

А.Камю эрх чөлөөний тухай асуудлыг авч үзэхдээ үхлийн тухай асуудалтай холбон тайлбарласан буй. Хүн өөрийнхөөрөө байж болох цорын ганц эрх чөлөө бол үхэлд хандах эрх чөлөө мөн. Үхлийг яг ёсоор нь хүлээн авахдаа түүний үр дагавар болох амьдралын үнэ цэнийг ойлгож буй тэр хүн л жинхэнээсээ эрх чөлөөтэй гэж үзсэн байдаг. Хүн өөрийнхөө болж бүтэж жаргаж цэнгэж яваа үедээ биш, харин ядарч зүдэрч түгшиж буй эцсийн эцэст үхлээ ирж буйг ухаарсан үедээ л өөрийгөө хэн болохоо жинхэнээр нь илчилдэг.

Бид амьдралын янз бүрийн нөхцөл байдалд ордог. Зарим нь биднийг өөрчилж, заримыг нь бид өөрчилж амьдардаг. Экзистенциализмд энэхүү нөхцөлийг эгзэгтэй нөхцөл гэдэг. Эгзэгтэй нөхцөлд орсноор хүн өөрийнхөө болоод оршин байгаа ертөнцийн амьдралыг ойлгож, ухаарах чадварыг олж авдаг. Гэтэл байгаагаараа хэзээд үлддэг эгзэгтэй нөхцөлүүд байдаг. Гайхах эргэлзэхийн зэрэгцээ бид тээнэгэлзэж байдаг. Түүний үзлээр, хүн угаасаа эрх чөлөөтэй төрдөг ба нийгэм болон хүн өөрөө өөрийнхөө заяагдмал эрх чөлөөгөө хязгаарлаж, дотоод мөн чанараасаа зугтааж амьдардаг. Энэ нь хүний амьдралыг утга учиргүйдлээр дүүрэн болгож, амьдралын үнэ цэнийг алдуулдаг байна.

Энэ бүхнээс үзвэл, А.Камюгийн философийн онцлогийг утга учиргүйдэл, тэрсэлдээн гэсэн үндсэн ойлголтууд нь илэрхийлдэг. Хүний амьдрал дахь утга учиргүйдэл нь ухаарч ойлгоогүй амьдралыг туулж өнгөрүүлэх нь өөрөө утга учиргүй хэрэг болохыг илэрхийлдэг ойлголт. Зүгээр л өдөр хоногийг өнгөрөөж амьдрах нь ухаант хүнд байж таарахгүй амьдрал юм.

А.Камюгийн абсурдист үзлээр, хүн өөрийнхөө хувьд болон нийгмийн чухал зүйлийн нэг болох үнэнийг зөвхөн шинжлэх ухааны танин мэдэхүйгээр бус, харин өөрийг нь оршин буйг нотлох, ертөнц дэх ахуйгаа мэдрэх мэдрэмжүүдийн тусламжтайгаар нээдэг бөгөөд хүний мөн чанарыг утга учиргүйдэл, мухардмал байдал тодорхойлдог байна. Энэхүү абсурдист үзэл нь түүнийг зарим судлаачид гутранги үзэлтэн гэж дүгнэхэд хүргэдэг боловч, үнэн хэрэгтээ утга учиргүйдлийг даван туулах арга замыг тэрсэлдээн хэмээх ойлголттой холбон авч үзсэнээрээ А.Камю бол харин ч өөдрөг үзэлтэн юм.

А.Камюгийн үзлээр, тэрсэлдээний мөн чанар нь хүний амьдрах арга зам болоход оршино. Тэрсэлдээн хэмээх ойлголтын агуулга нь энэ амьдрал утга учиргүй юм байна. Би энэ ертөнцөд ганцаараа гээгдсэн. Миний амьдрал бол хэнийх ч биш зөвхөн миний л амьдрал. Тиймээс би л өөрийхөө амьдралыг утга

²¹ А.Ф.Зотов, Ю.К.Мельвиль. “Западная философия XX века”. М., 1998. с.310

учиртай, үнэ цэнэтэй болгох ёстой гэдгээ ухамсарласан хүний хийх үйлдэл гэдгийг илэрхийлдэг. Тэрсэлдээний ачаар л амьдралыг утга учиртай, үнэ цэнэтэй, аз жаргалтай, сайн сайхан болгох боломжтой. Ач холбогдолгүй, утгагүй зүйлээс хурдан салж, өөрийгөө өөрчлөхөд амьдралын утга учир оршино. Утга учиргүйдлийг хүний амьдралыг тодорхойлогч, мөн чанарыг нь нээн илрүүлэгч хэмээн ойлгож чадаж байгаа хүн бол амьдралаа утга учиртай болгохыг, өөрөө зорилго, хүсэл тэмүүлэлтэй идэвхитэй амьдрахыг зорьж байгаа хүн юм. Тэр хэзээ ч энэ амьдралд бууж өгөхгүй бөгөөд, тэрсэлж амьдарч чадна.

Түүнээс гадна хүний орших өөр нэг гол зүйл нь өөртөө итгэх итгэл, хариуцлага хүлээх чадвар байдаг. Хүн нийгмээс, амьдралаас хүссэнээ олж авах боломжгүй байлаа ч гэсэн өөрийнхөө хувьд амьдралын утга учрыг тодорхойлох боломжтой ажээ. Өөрөөр хэлбэл, хүний амьдралын утга учир, үнэ цэнэ хувь хүнээс өөрөөс нь л шалтгаалдаг. Хүн бол хувь заяаныхаа боол биш, эзэн нь байх хэрэгтэй бөгөөд өөрийн амьдралын утга учиргүйдлийн шалтгааныг эцсийн эцэсг нийгэм болон бусад хүмүүсээс хайх хэрэггүй, харин өөрөөсөө хайх нь зүйтэй гэсэн хэрэг юм.

А.Камюгийн философийн өөр нэг ойлголт нь ганцаардал хэмээх ойлголт юм. Ганцаардал бол нэг талаасаа нийгмээс тусгаарлагдсан, гадуурхагдсан байдал, харин нөгөө талаасаа энэ нь хүний өөрөө өөрийгөө танин мэдэх, өөрийнхөө мөн чанар, оршихуйгаа эрж хайх нэгэн төрлийн эрэл хайлт юм. Хүн ганцаардсан үедээ л өөрийнхөө тухай бодож эхэлдэг. Тиймээс ганцаардал нь нийгмээс түр ч атугай ангижирч байгаа тэрсэлдээний нэг хэлбэр гэж үзэж болох юм.

Дүгнэлт

А.Камюгийн абсурдизмын онцлог нь хүн өөрийнхөө оршихуйг, амьдралын утга учрыг, би хэн бэ? гэдгээ тодорхойлсноор илүү идэвхитэй, үнэ цэнэтэй амьдрах болно гэсэн үзэл санааг дэвшүүлж, мөн тэрсэлдээн болон утга учиргүйдэл нь хүний орших уу, эс орших уу гэдгийг тодорхойлогч хоёр туйл болохыг тайлбарласанд оршино.

Ном зүй

- Р.Дарьхүү. "Дорнын болон өрнийн философи дахь хүний асуудал". Дэд докторын диссертаци. УБ., 1996
- А.Камю. "Хар элгийн хүн". УБ., 2007
- А.Камю. "Сизифийн тухай домог". Орч.Ж.Отгонбаяр.- "Философи, шашин судлал". №7. УБ., 2007.
- В.Г.Горбачев. "История философии". Брянск., 2000
- А.Ф.Зотов, Ю.К.Мельвиль. "Западная философия XX века". М., 1998
- А.Камю. "Избранное". М., 1989
- А.Камю. "Миф о Сизифе", "Бунтующий человек". М., 1998
- Е.П.Кушкин. "Альбер Камю". М., 1982
- А. Camus. "The Stranger", "The Rebel", "Absurd man", "The Fall", "A happy death", "Between Yes and No", "Myth of Sisyphos", "The Plague"- from www.google.com
- www.best.ru